

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур дүүргийн Багануур гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/88/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 99102291 Цахим хаяг: ichinhorloo@gmail.com

Аудитын менежер: И.Туяа
Утас: 99298711 Цахим хаяг: Tuyaishjamts@gmail.com

Аудитор: С.Удвал Цахим хаяг: udval@gmail.com

Аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК
Утас: 77820808 Цахим хаяг: NITS Audit

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Алч. 03.15 № 504

танай _____-ны № _____-т

БАГАНУУР ГЭРЭЛТҮҮЛЭГ
ЧИМЭГЛЭЛ ААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.БАТНАСАН ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур дүүргийн Багануур-Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, эдийн засгийн зорилтот түвшин, тодруулгуудад аудит хийлээ.

Багануур дүүргийн Багануур-Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолыг үндэслэн Багануур дүүргийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн “Багануур дүүргийн Багануур-Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ыг татан буулгах тухай” тогтоол гаргасан байна.

Дээрх тогтоолд тус ААТҮГ-ын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтын үр дүн гарах хүртэл үргэлжлүүлэх гэсний дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ныг дуустал үйл ажиллагааг нь хэвийн үргэлжлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн үр нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Багануур-Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-т Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2021 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн А/197 тоот “Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, 2022 оны 6 сарын 16-нд

15 жилийн хугацаатай, аж ахуйн зориулалтаар 1000 м2 газрыг эзэмшүүлэх гэрээ байгуулан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

Гэвч Багануур дүүргийн ИТХ-аас уг газрыг үнэлж, бүртгэлд тусгах тухай тогтоол, шийдвэр гаргаагүйгээс шалтгаалан өнөөг хүртэл газрыг тус байгууллагын бүртгэл, тайланд тусгагдаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Багануур-Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Багануур-Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын 2023 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 4 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл нь 94.0 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	46,474,678.13	6,854,339.54
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	2,430,169.87	2,077,919.01
1.1.6	Бараа материал	48,551,654.69	79,197,070.42
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	217,547.42	100,977.04
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,674,050.11	88,230,306.01
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	124,252,816.29	94,233,653.89
1.2.2	Биет бус хөрөнгө	1,905,000.00	1,365,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	126,157,816.29	95,598,653.89
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	223,831,866.40	183,828,959.90
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		511,827.86
2.1.1.2	Цалингийн өглөг	167,712.30	0.0
2.1.1.3	Татварын өр	402,259.49	7,275,769.50
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	569,971.79	7,787,597.36
2.2	Өр төлбөрийн нийт дүн	569,971.79	7,787,597.36
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	165,216,667.00	165,216,667.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,000,000.00	6,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	52,045,227.61	4,824,695.54
2.3.10	Тайлангийн үеийн ашиг	-	(54,833,374.50)
2.3.11	Өмнөх үеийн ашиг	52,045,227.61	59,658,070.04
2.3.11	Эздийн өмчийн дүн	223,261,894.61	176,041,362.54
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	223,831,866.40	183,828,959.90

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	657,508,727.27	953,309,090.92
2	Борлуулалтын өртөг	643,534,153.06	904,238,125.81
3	Нийт ашиг(алдагдал)	13,974,574.21	49,070,965.11
4	Бусад орлого	28,861,140.00	79,302,935.23
5	Орлогын дүн	28,861,140.00	79,302,935.23
6	Ерөнхий ба удирдлагын зардал	2,923,947.30	183,207,274.84
7	Зардлын дүн	2,923,947.30	183,207,274.84

8	Бусад ашиг (алдагдал)	(2,889,600.00)	0.00
9	Олз гарзын дүн	(2,889.600.00)	0.00
10	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	37,022,166.91	(54,833,374.50)
11	Орлогын татварын зардал	3,702,216.69	-
12	Татварын дараах ашиг (алдагдал)	33,319,950.22	(54,833,374.50)
13	Тайлангийн үеийн цэвэр ашиг(алддагдал)	33,319,950.22	(54,833,374.50)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын31-ний үлдэгдэл	165,216,667.00		18,725,277.39	183,941,944.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсанүлдэгдэл	165,216,667.00		18,725,277.39	183,941,944.39
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			33,319,950.22	33,319,950.22
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		6,000,000.00		6,000,000.00
9	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	165,216,667.00	6,000,000.00	52,045,227.61	223,261,894.61
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			7,612,842.43	7,612,842.43
11	Залруулсанүлдэгдэл	165,216,667.00	6,000,000.00	59,658,070.04	230,874,737.04
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(54,833,374.50)	(54,833,374.50)
17	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	165,216,667.00	6,000,000.00	4,824,695.54	176,041,362.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	752,414,351.00	1,137,244,135.88
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Татаас, санхүүжилтийн орлого	723,259,600.00	1,048,640,000.00
	Бусад мөнгөн орлого	29,154,751.00	88,604,135.88
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	732,193,028.36	1,170,574,574.47
	Ажиллагчдад төлсөн	179,751,159.00	286,997,212.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	56,647,792.00	92,885,505.76
	Бараа материал худалдан авахад төлсөн	186,936,614.35	336,190,108.00

	Ашиглалтын зардалд төлсөн	164,417,596.63	250,124,511.34
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	40,611,500.00	55,919,260.00
	Татварын байгууллагад төлсөн	62,000,913.63	67,217,895.68
	Даатгалын төлбөрт төлсөн	650,400.00	870,690.00
	Бусад мөнгөн зарлага	41,177,052.75	80,369,391.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,221,322.64	(33,330,438.59)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн зарлагын дүн (-)	4,652,500.00	6,289,900.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,752,500.00	6,289,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	900,000.00	-
2.2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,652,500.00)	(6,289,900.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	15,568,822.64	(39,620,338.59)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,905,855.49	46,474,678.13
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,474,678.13	6,854,339.54

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Санхүүжилтийн орлого	723,259,600.00	788,640,000.00	953,309,090.92	164,669,090.92	120.9
2	Бусад орлого	28,861,200.00	25,000,000.00	79,302,935.23	54,302,935.23	317.2
Нийт орлогын дүн		752,120,800.00	813,640,000.00	1,032,612,026.15	218,972,026.15	126.9
1	Цалин	198,973,200.00	289,723,600.00	286,997,200.00	2,726,400.00	99.1
2	Үр дүнгийн урамшуулал	23,320,000.00	50,000,000.00	50,341,500.00	(341,500.00)	100.7
3	НДШ	32,404,500.00	80,000,000.00	51,576,300.00	28,423,700.00	64.5
4	Ашиглалтын зардал /асаалт/	147,740,900.00	200,000,000.00	245,803,920.00	(45,803,920.00)	122.9
5	Түрээсийн зардал	9,492,000.00	15,000,000.00	19,279,300.00	(4,279,300.00)	128.5
6	Албан томилолтын зардал	1,120,000.00	1,500,000.00	1,610,000.00	(110,000.00)	107.3
7	Элэгдлийн зардал	48,473,100.00	50,000,000.00	44,242,300.00	5,757,700.00	88.5
8	Хөдөлмөр хамгааллын зардал	10,563,400.00	19,000,000.00	27,455,200.00	(8,455,200.00)	144.5
9	Зар сурталчилгааны зардал	362,200.00	1,400,000.00	250,000.00	1,150,000.00	17.9

10	Бичиг хэргийн зардал	1,211,900.00	1,500,000.00	1,734,600.00	(234,600.00)	115.6
11	Шуудан холбооны зардал	2,615,700.00	2,900,000.00	1,902,600.00	997,400.00	65.6
12	Шатахууны зардал	27,250,000.00	30,000,000.00	35,814,500.00	(5,814,500.00)	119.4
13	Шатах тослох материал	1,650,000.00	1,800,000.00	1,760,000.00	40,000.00	97.8
14	Сэлбэг материал, засвар	141,465,100.00	190,000,000.00	215,000,000.00	(25,000,000.00)	113.2
15	Сургалтын зардал	858,000.00	2,000,000.00	250,000.00	1,750,000.00	12.5
16	Татвар /НӨАТ/-н зардал	62,000,900.00	95,000,000.00	67,217,900.00	27,782,100.00	70.8
17	Бусад зардал	9,300,000.00	25,000,000.00	36,210,070.00	(11,210,070.00)	144.8
-	Үндсэн үйл ажиллагааны зардал	718,800,900.00	1,054,823,600.00	1,087,445,390.00	(32,621,790.00)	103.1
	<u>Г.Татварын өмнөх ашиг</u>	33,319,900.00	(241,183,600.00)	(54,833,363.85)	186,350,236.15	22.7
	<u>Д.Татварын зардал</u>	3,702,200.00				
	<u>Е.Тайлант үеийн цэвэр ашиг</u>	33,316,900.00	(241,183,600.00)	(54,833,363.85)	186,350,236.15	22.7
	<u>Орлогын 1 төг-т ногдох зардал</u>	1.02	1.30	1.05	0.15	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 60,399.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 7,549.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан, 7,787.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн, 45,062.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
7,549.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	7,549.1					1	7,549.1				
Дүн	1	7,549.1					1	7,549.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
7,787.6 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн	1	7,787.6					1	7,787.6				

Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй газрыг бүртгэж, тайлагнаагүй	1	0.0					1	0.0				
Дүн	2	7,787.6					2	7,787.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	39,617.7	1	39,617.7		
Дүн	1	39,617.7	1	39,617.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Ажиллагсад үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлын үр дүн, ашиг, орлоготой нь уялдуулалгүй, хавтгайруулан олгож, батлагдсан төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулсан	1	5,445.0	1	5,445.0		
Дүн	1	5,445.0	1	5,445.0		
Нийт дүн	2	45,062.7	2	45,062.7		